



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 23 өдөр

Дугаар 1176

Бат-Өлзий сум

Г Ажлын хэсэг байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.9 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Албан хаагчдад компьютер, техник хэрэгсэл нийлүүлэх ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Г.Сугар (иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хяналт, шалгалт, олон нийттэй харилцах мэргэжилтэн)

Гишүүд: Б.Пүрэвсүрэн (Нягтлан бодогч)

Ц.Маргад-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын нярав)

2. Захиалагчийн техникийн тодорхойлолт, шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа байдлыг хянан үзэж, гэрээний шаардлагыг биелүүлсэн нөхцөлд акт үйлдэж хүлээн авч танилцуулахыг ажлын хэсгийн дарга (Г.Сугар)-д даалгасугай.

3. Орон нутгийн өмчид бүртгэх шаардлагатай хөрөнгийг өмчид бүртгэж, ашиглалт, хамгаалалтанд байнгын хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдуулам)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ Н.ОРХОНТУУЛ

